



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/300

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 20.6 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалт, Тусгай зөвшөөрлийн комиссын 2023 оны 8 сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаанд түдгэлзүүлэх байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Төгсдэлгэр)-д даалгасугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ

141224312

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
08 дугаар сарын 12 өдрийн А/300
дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮР ТҮДГЭЛЗҮҮЛЭХ
БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл, чиглэл	Хаяг, байршил
Нэг. Тусгай зөвшөөрлийг 3 сараар түдгэлзүүлэх байгууллага			
1	"Аглаг мед" ХХК УБГД:9011234150 РД: 24497	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх	УБ хот, ЧД, 4-р хороо, Нэгдсэн Үндэсний гудамж 100 тоот
2	"Эм Кэй Эм Ар" ХХК УБГД:9019078054 РД: 5870291	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх	УБ хот, СБД, 1-р хороо, Юү Би Эйч төвийн 1218, 1208 тоот

---000---